

ЦССҮТ-ийн 2023 оны тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр

№	Шалгуур үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Тайлбар
2.1 Нийтлэг шалгуур үзүүлэлт				
1	Тухайн мэргэжлийн чиглэлээр явуулсан мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалт болон хамрагдагсдын тоо	Төрөлжсөн мэргэшлийн сургалт 2, Мэргэжил дээшлүүлэх сургалт 2	Төрөлжсөн мэргэшлийн сургалт 2, Мэргэжил дээшлүүлэх сургалт 2	<p>Төв нь Эрүүл мэндийн сайдын тушаал болон Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын тушаалын дагуу “Төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн болон мэргэжил дээшлүүлэх” сургалтыг жилд 2 удаа зохион байгуулж, 2023 оны байдлаар нийт 3 эмч, 1 био-анагаахын мэргэжилтэн, 4 сувилагч амжилттай суралцаж төгссөн ба одоо суралцаж байгаа 3 их эмч, 4 сувилагч байна. Үүнд:</p> <p>1. 2023 оны 4-10 дугаар сард Эмнэлзүйн цус сэлбэлт судлалын төрөлжсөн мэргэшлийн сургалтанд 3 их эмч, Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологич мэргэжил дээшлүүлэх сургалтанд 1 Био-анагаахын мэргэжилтэн суралцаж, бүгд төгссөн.</p> <p>2. 2023 оны 5-8 дугаар сард Цус, цусан бүтээгдэхүүний технологич сувилагчийн мэргэжил дээшлүүлэх сургалтад 5 сувилагч элсэн суралцаж, 4 сувилагч төгссөн.</p> <p>3. 2023 оны 10 дугаар сараас Эмнэлзүйн цус сэлбэлт судлалын төрөлжсөн мэргэшлийн сургалтанд 3 их эмч, Цус, цусан бүтээгдэхүүний технологич сувилагчийн мэргэжил дээшлүүлэх сургалтанд 4 сувилагч элссэн суралцаж байна.</p>
2	Тухайн мэргэжлийн чиглэлээр хийж буй: - Судалгаа, эрдэм шинжилгээний хүлээлгэн өгсөн тайлан - Хэвлэгдсэн сэтгүүл болон хэвлэл - Эрдмийн зэрэг хамгаалсан хүний тоо	2 9 2	1 15 4	<p>Төв нь мэргэжлийн чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг тогтмол хийж, үндсэн үйл ажиллагаандаа судалгаа, шинжилгээний үр дүнг тогтмол ашигладаг бөгөөд 2023 онд нийт 16 эрдэм шинжилгээний өгүүлийг гадаад, дотоодын сэтгүүлд болон өөрийн эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн хураангуйд хэвлүүлсэн байна. Үүнд:</p> <p>Гадаадын сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл:</p> <ul style="list-style-type: none"> Insights into the diversity of blood donation practice across Asia: How blood collection agencies adapt donor criteria and processes to their population <i>Yoke-Lin Fung¹, Leonardo Brereton Cavalli¹ Ramir Moreno Alcantara², Jen-Wei Chen³, Rebecca Donkin⁴, Pawinee Kupatawintu⁵, Sahit Tadsomboon⁵, So-Yong Kwon⁶, Cheuk-Kwong Lee⁷, Veera Sekaran Nadarajan⁸, Erdenebayar Namjil⁹, Solongo Bat⁹, Takeshi Odajima¹⁰, Nelson-Hirokazu Tsuno¹⁰, Suchet Sachdev¹¹, Ratti Ram Sharma¹¹, Rukmono Siswishanto¹², Teguh Triyono¹²,</i> <p>Дотоодын сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл:</p>

				<ul style="list-style-type: none"> • Нарийн навчит цахилдагт агуулагдах флаваноидыг хавдрын загварт туршсан дүн <i>С.Идэржавхлан, Ч.Жадамба, э.Сурмаажав, О.Эрдэнэзаяа, Ч.Гансүх, Э.Мөнхсоёл, Ц.Анужин, Н.Эрдэнэбаяр, Н.Гиймаа</i> <p>Цус сэлбэлт судлалын салбарын олон улсын Эрдэм шинжилгээний XX хурлын илтгэлийн хураангуйд ажиллагсдын хэвлүүлсэн өгүүллүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Цусны албаны 2013-2022 оны зарим үзүүлэлтийг судалсан <i>Ш.Соёлмөнх¹, Э.Энхболор¹, Н.Эрдэнэбаяр¹</i> • ЦССҮТ-ээр 2022 онд үйлчлүүлсэн доноруудын цус өгөлтийн байдлыг судалсан дүн <i>Ч.Далайцэрэн,¹ Ш.Соёлмөнх¹, Н.Батцэрэн¹, Н.Эрдэнэбаяр¹</i> • Цус, цусан бүтээгдэхүүний хаягдалд хийсэн үнэлгээний дүн <i>Б.Дуламсүрэн,¹ Н.Халиун,¹ Б.Оргил¹, Б.Танхилмаа.¹ П.Цэндхүү</i> • Цусны доноруудын дунд гепатитийн В, С вирусийг судалсан нь <i>Ж.Нармандах¹, М.Цэрэндэжид¹, Э.Тунгалагтуяа¹, Н.Эрдэнэбаяр¹ Б.Цацралт-Од²</i> • Анти-А₁ эсрэгбие агуулсан ав бүлэгтэй өвчтөнд тохирох цус сонгосон тохиолдлын судалгаа <i>М.Цэрэндэжид¹, Н.Баяртогтох¹, Д.Оюунболд¹, Д.Сайра¹</i> • Гепатит В вирусийн шалтгаант элэгний хавдар болон цусны АВО бүлгийн хамаарал <i>А.Оюунтуяа¹, Б.Анударь¹, Д.Сайра¹, Б.Хишиг-Очир¹</i> • Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн хөлдөөсөн шинэ сийвэнд агуулагдах VIII факторын идэвхийг харьцуулсан судалгаа <i>Б.Оргил.¹, Н.Халиун.¹, М.Цэрэндэжид¹, Б.Анударь.¹, Б.Долгормаа.¹ Н.Энхтуул.¹</i> • ЦССҮТ-ийн цус цусан бүтээгдэхүүний зардлыг тооцсон дүн <i>С.Алтаннамар¹ Ш.Соёлмөнх¹, Н.Эрдэнэбаяр¹</i> • Ковид-19 цар тахлын үеийн цус цуглуулалтыг цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээтэй харьцуулан судлах нь <i>Д.Одмаа¹, Н.Удвал², Б.Ижилбаатар³</i> • Цусны байнгын доноруудын төмрийн нөөцийг судалсан нь <i>Э.Тунгалагтуяа¹, Г.Мөнхгэрэл², Э.Золбоо², Д.Одмаа², Х.Чулуунцэцэг², Б.Буянтогтох²</i> • Донорын эрүүл мэндийн үзлэг асуумжаар түр болон бүр хасагдсан шалтгааныг цахим сүлжээний мэдээллийг харьцуулан судалсан нь <i>Х.Мядагмаа¹, Н.Халиун¹, Д.Наранхүү¹, Ё.Улсболд¹, Л.Өлзийбаяр¹</i> • Цусны донороос хасагдалтын шалтгааныг судалсан нь
--	--	--	--	---

				<p><i>Э.Дашгарав¹, Б.Ижилбаатар¹, Н.Эрдэнэбаяр¹</i></p> <ul style="list-style-type: none"> Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн донор зохион байгуулалтын тасгийн цус цуглуулалтын дараах хаягдалд хийсэн судалгаа <i>Э.Чагцалдулам¹, Э.Энхболор², Ж.Нармандах², Дашгарав³, Буянтогтох³</i> Элэг шилжүүлэн суулгах мэс заслын үеийн цус цусан бүтээгдэхүүний хэрэглээг судалсан нь <i>Б.Өнөрцэцэг¹, Н.Халиун², Т.Хулан²</i> <p>Эрдмийн зэрэг хамгаалсан хүний тоо: 2023 онд Глобаль удирдагч их сургуулийн “Эрүүл мэндийн бодлого, удирдлага” чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> Үйлдвэрлэлийн тасгийн технологич сувилагч Б.Өнөрцэцэг “Элэг шилжүүлэн суулгах үеийн цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээг судалсан дүн” сэдвээр Сувилахуй үйлчилгээний албаны дарга Ж.Нармандах “Цусны доноруудын дунд гепатитийн В, С вирусийг судалсан нь” сэдвээр Донор зохион байгуулалтын тасгийн технологич сувилагч Д.Одмаа “Ковид-19 цар тахлын үеийн цус цуглуулалтыг цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээтэй харьцуулан судлах нь” сэдвээр Донор зохион байгуулалтын тасгийн технологич сувилагч Э.Дашгарав “Цусны донороос хасагдалтын шалтгааныг судалсан нь сэдвээр тус тус хамгаалсан.
3	Сэлгэн ажлуулсан эмч, сувилагчдын тоо /хөдөө орон нутаг болон эмнэлэг хооронд/	5	2	<p>Цусны аюулгүй байдлыг ханган ажиллах, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор хүсэлт гаргасан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг ажлын байрны сургалтаар дагалдуулан сургадаг. Энэ онд Сүхбаатар аймгийн Нэгдсэн эмнэлгийн лаборант, Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн лабораторийн их эмч, нийт 2 мэргэжилтнийг Нэгдсэн лабораторийн тасагт Иммуногематологийн шинжилгээнүүдийг хийх аргачлалд, нарийн мэргэжлийн эмчийн хяналтан дор 5 хоногийн ажлын байрны сургалтаар сургасан.</p> <p>Мөн төвийн тоног төхөөрөмжийн инженер Б.Додьгалсан Дундговь, Дорнод, Хэнтий, Сэлэнгэ аймгуудын цусны салбар төвүүдэд очиж, эмнэлгийн тоног төхөөрөмж засварлан, мэрэгэжил арга зүйгээр ханган ажилласан.</p>
М ө н	Эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдын үзлэгт хамрагдсан хувь	97%	94%	<p>Төв нь ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор доорх арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.</p> <ul style="list-style-type: none"> 2023 оны 03-р сарын 02-ны өдөр Шүдний өвчний тархалт болон цоорлын эрчмийг бууруулах, шүдээ арчлах зөв дадлыг хэвшүүлэх зорилготой “Эрүүл бие-эрүүл шүд” аяны хүрээнд Нийслэлийн шүд эрүү нүүрний төвтэй хамтран эмч ажиллагсдад шүд, амны хөндийн урьдчилан

					<p>сэргийлэх үзлэгийг зохион байгуулж 40 эмч, ажилтан хамрагдсан. Үүнээс шүдний цооролтой 30, шүдний чулуутай 30, хиймэл шүдний хийлгэх шаардлагатай 21, шүд авахуулах шаардлагатай 3 хүн байсан. Уг үзлэгийн хүрээнд эмчлэн эрүүлжүүлэх тусламж үйлчилгээг эрүүл мэндийн даатгалаар хамрагдах боломжийг бүрдүүлж 12 эмч, ажилтан шүдний эмчилгээ үйлчилгээ хийлгэсэн. Шүд угаалтыг сайжруулах зорилгоор Баянзүрх дүүргийн Улаан загалмайн хороо, Эрүүл мэндийн төвтэй хамтран “Амны хөндийн эрүүл ахуй “ сэдвээр сургалт хийж, шүдний оо, сойзоор хангаж өгснөөр үдийн хоолны дараа ажлын байрандаа шүдээ угааж хэвшсэн.</p> <ul style="list-style-type: none"> • 2023 оны 4 сарын 24-ны өдөр Лабораторийн ажилтны 7 хоногийг угтан Нэгдсэн лабораторийн тасаг нь нийт ажиллагсдад цусанд ферритин, өтгөнд хеликобактери үзэх шинжилгээ хийж, хеликобактер тодорхойлох шинжилгээнд 44 ажилтан хамрагдсанаас 39 ажилтан эерэг, 5 ажилтан сөрөг гарсан бол, ферритиний шинжилгээнд 48 ажилтан хамрагдаж 3 ажилтан лавламж хэмжээнээс өндөр гарсан байна. • Ажиллагсдын урьдчилан сэргийлэх үзлэгээр Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн “Зүрх судасны багц”-ыг сонгон 2023.08.30-09.15-ны өдрүүдэд үзлэг, шинжилгээг зохион байгуулсан. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Зүрхний цахилгаан бичлэг • Цусны дэлгэрэнгүй шинжилгээ • Шээсний дэлгэрэнгүй шинжилгээ • АСАТ • АЛАТ • Альбумин • Амилаза • Креатинин • Шээсний хүчил • Бамбайн триод өдөөгч даавар • Өлөн үеийн сахар • Үе мөчний С урвалж • Өөх тосны солилцооны шинжилгээнд хамруулсан ба шинжилгээнд нийт хамрагдах ёстой 66 ажилтнаас 62 ажилтан хамрагдаж, нийт ажиллагсдын 94% хамрагдсан.
5	Тухайн жилд тасралтгүй сургалтын	Эмчийн хувь	0	12	Төвийн хэмжээнд нийт 12 эмч ажиллаж, кредиттэй сургалтанд хамрагдсан бөгөөд 2 эмч АШУУИС-ын Олон улсын Сайбер их сургуулийн Магистрийн хөтөлбөрөөр кредит цагаа дуйцүүлж, тооцуулсан.

	кредитын шаардлага хангасан				
6		Сувилагчийн хувь	0	24	Төвийн хэмжээнд нийт 24 сувилагч ажиллаж, кредиттэй сургалтанд хамрагддаг бөгөөд энэ онд бүх сувилагч нар кредитээ бүрэн сунгуулсан.
7		Эх баригчийн хувь	-	-	-
8	Байгууллагуудын өрийн хэмжээ	74,9 сая		8,2 сая	2022 оны жилийн эцсээр 74,998.0 сая төгрөгийн өр төлбөртэй байснаас тайлант онд өрт өлбөрийн хэмжээг 8,2 сая төгрөг болгож буурууллаа.

2.2. ЦССҮТ-ийн үйл ажиллагааны өвөрмөц үзүүлэлт

1	Тухайн жилд шинээр бүртгэгдсэн донорын тоо	Нийт цус цуглуулалт 32295, үүнээс шинэ донор 10890	Нийт цус цуглуулалт 32956, үүнээс шинэ донор 11402	2023 онд 32956 донороос цус, цусны бүрэлдэхүүн хэсэг цуглуулсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 2%-иар өссөн үзүүлэлттэй байна. Нийт цусаа өгсөн доноруудын 34,6% буюу 11402 нь шинэ донор буюу анх удаа цусаа өгч байгаа донорууд байна.
2	Бүртгэлтэй донорын тоо, үүнээс байнгын донорын эзлэх хувь	Бүртгэлтэй донор 19715/ Байнгын донор 65,1%	Бүртгэлтэй донор 19955/ Байнгын донор 65,4%	2022 онд бүртгэлтэй донорын тоо 19715 байсан бол 2023 онд 19955 болж, 1,2%-иар өссөн байна. Үүнээс байнгын донорын эзлэх хувь 65,4% байна. Тогтмол хугацаанд цусаа бэлэглэдэг донорын эзлэх хувь 60%-иас дээш байх нь цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм.
3	Тухайн жилийн цус өгөлтийн тоо, өсөлт	32295	32956	2022 онд нийт 32295 донороос цус цуглуулж байсан бол 2023 онд цус цуглуулалт 32956 болж өссөн. Мөн тухайн жилийн төвийн батлагдсан цус цуглуулалтын төлөвлөгөө 110%-тай биелсэн ба өмнөх онтой харьцуулахад 2%-иар өссөн үзүүлэлттэй байна.
4	ЦЦБ-ний үйлдвэрлэлийн тоо хэмжээний өсөлт, нэр төрлөөр, нэгжээр	36 нэр төрөл/ 90.494 нэгж	36 нэр төрөл 92.631 нэгж	2022 онд 36 нэр төрлийн 90,494 нэгж цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бол 2023 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн байдлаар 36 нэр төрлийн 92631 нэгжийг үйлдвэрлэсэн ба үйлдвэрлэлийн төлөвлөгөө 97%-ийн гүйцэтгэлтэй байна.

5	Тайван, онцгой байдлын үеийн нөөцийн бүрдүүлэлтийн хэмжээ /нэгжээр/	23,715 нэгж	26465 нэгж	Тайван, онцгой байдлын үеийн цус, цусан бүтээгдэхүүний нөөц 26,465 нэгж буюу өмнөх оноос 2,750 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна. Онцгой байдлын үеийн бүтээгдэхүүний нөөцийг төрлөөр нь ангилбал: - Улаан эсийн бүтээгдэхүүн 964 - Сийвэнгийн бүтээгдэхүүн 25,370 - Криопреципитат 131 нэгж тус тус байгаа нь өмнөх оны мөн үеэс 10.4%-иар өссөн үзүүлэлт юм.
6	Цус цусан бүтээгдэхүүний хангалтын хувь	100%	100%	2023 онд улсын болон хувийн хэвшлийн нийт 83 эмнэлэгтэй ЦЦБ нийлүүлэх гэрээ байгуулан ажиллаж, 19,287 удаагийн захиалгаар 73 эмнэлэгт 60,823 нэгж цус цусан бүтээгдэхүүн олгосон бөгөөд гэрээт эмнэлгүүдийн захиалгыг бүрэн нийлүүлсэн. Олгогдоогүй бүтээгдэхүүний захиалга байхгүй болно.
7	Цус сэлбэлтийн хүндрэлийн хувь /Үндэсний хэмжээнд/	8	5	Үндэсний хэмжээнд цус сэлбэлттэй холбоотой урвал хүндрэлийг мэдээлсэн тоо 2022 онд 8 /4 хүндэвтэр, 4 хөнгөн/ урвал хүндрэл, 2023 онд 5 хөнгөн урвал хүндрэл бүртгэгдсэн байна. Цус сэлбэлттэй холбоотой хөнгөн урвалыг бүртгэж, мэдээний сан үүсгэн ажилладаг бөгөөд хүнд, хүндэвтэр урвал хүндрэлд дүн шинжилгээ хийж, тайланг харьяа эмнэлгийн цус сэлбэлтийг зохицуулах салбар зөвлөлд албан бичгээр хүргүүлдэг. Дээрх тохиолдлуудын шалтгааныг судлахад цус, цусан бүтээгдэхүүн сэлбэсэнтэй холбоогүй болохыг тогтоосон.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ЦУСНЫ ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ДАРГА *А. Амарзаяа* А.АМАРЗАЯА

ХЯНАСАН:

ДОТООД АУДИТОР

С

С.АЛТАННАМАР